



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 оны 07 сарын 10 өдөр

Дугаар A/220

Улаанбаатар хот

МУИС-ийн магистр, докторын хөтөлбөрт
суралцагч элсүүлэх журам шинэчлэн батлах тухай

Монгол улсын дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, 12.1.6, МУИС-ийн дүрмийн 4.5.8.3, 4.5.8.7, дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. МУИС-ийн Захиргааны зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 30, 07 дугаар сарын 09-ны өдрүүдийн хурлын шийдвэрийн дагуу "МУИС-ийн магистр, докторын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, 2015-2016 оны хичээлийн жилийн намрын улирлын магистр, докторын хөтөлбөрийн бүртгэл, элсэлт хичээл эхлэх хугацааг 2 дугаар хавсралтаар.
2. Журмыг 2015-2016 оны хичээлийн жилийн намрын элсэлтээс эхлэн мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төгсөлтийн дараах сургууль /Б.Отгонтөгс/, Сургалтын нэгдсэн алба /Ч.Ундрям/, Мэдээллийн технологийн алба /А.Баатарбилэг/, бүрэлдэхүүн сургуулийн захирал /Ж.Эрдэнэбулган, Н.Батнасан, Н.Баатарбилэг, Б.Баяртгтох, С.Баттулга/, сургалтын албаны эрхлэгч /Б.Амарбаясгалан, Б.Даваасүрэн, Г.Энхбаяр, Ц.Амартайван, Д.Болормаа/ нарт үүрэг болгосугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан МУИС-ийн захирлын 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/425 тоот тушаалаар батлагдсан "МУИС-ийн магистр, докторын хөтөлбөрт оюутан элсүүлэх түр журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



Р.БАТ-ЭРДЭНЭ

20151288

Захирлын 2015 оны 07 дугаар сарын 10 -ны
өдрийн дугаар тушаалын 1 дүгээр хавсралт
120

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН МАГИСТР, ДОКТОРЫН
ХӨТӨЛБӨРТ СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

1. Ерөнхий зүйл

- 1.1. МУИС-ийн магистр, докторын хөтөлбөрт суралцагч элсүүлэхэд БШУ-ны сайдын 2014 оны А/370 дугаар тушаалаар баталсан “Магистр, докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам”, МУИС-ийн Захирлын тушаалаар баталсан 2015 оны 203 тоот “МУИС-ийн сургалтын журам”, МУИС-ийн Захирлын тушаалаар баталсан 2014 оны 214 тоот “МУИС-д гадаадын иргэнийг суралцуулах журам” болон энэхүү журмыг (цаашид “журам” гэнэ) баримтална.
- 1.2. МУИС-ийн магистрын өдөр, эчнээ хөтөлбөр, докторын өдөр, эчнээ хөтөлбөрт суралцагч элсүүлэх элсэлтийн үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.3. МУИС-ийн магистр, докторын хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргагчийг “бүртгүүлэгч”, элсэлтийн шалгалт өгч элсэх болзол хангасан бүртгүүлэгчийг “элсэгч”, элсэлтийн цахим бүртгэлийн системийг “бүртгэлийн систем” гэнэ.
- 1.4. Элсэлтийн төв комиссын даргаар Сургалт эрхэлсэн дэд захирал, нарийн бичгийн даргаар Сургалтын нэгдсэн албаны дарга, гишүүдээр Төгсөлтийн дараах сургуулийн захирал, бүрэлдэхүүн сургуулийн захирал, Мэдээллийн технологийн албаны дарга, Сургалтын нэгдсэн албаны хөтөлбөр хариуцсан ахлах мэргэжилтэн, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, магистр, докторын асуудал хариуцсан мэргэжилтэн, элсэлт, төгсөлт хариуцсан мэргэжилтэн, гадаад оюутан хариуцсан мэргэжилтэн, бүртгэл хариуцсан мэргэжилтэн, Төгсөлтийн дараах сургуулийн мэргэжилтэн, салбар комиссын даргаар бүрэлдэхүүн сургуулийн захирал, нарийн бичгийн даргаар сургалтын албаны эрхлэгч, гишүүдээр салбар/хөтөлбөр хариуцсан дэд захирал, элсэлт, төгсөлт хариуцсан мэргэжилтэн, бүртгэл хариуцсан мэргэжилтэн нарыг тус тус МУИС-ийн Захирлын тушаалаар томилно.
- 1.5. Эзэмшсэн бакалавр, магистрын мэргэжил нь өөр чиглэл (эрхзүйн хөтөлбөрөөс бусад)-тэй элсэгчийг харгалзах өмнөх түвшний мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлүүдийг нөхөн судлах нөхцөлтэйгөөр магистр, докторын хөтөлбөрт

элсүүлнэ. Магистр, докторын хөтөлбөрт нөхцөлтэйгээр элсэгч нь элссэн хөтөлбөрийнхөө харгалзах түвшний мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлээс 15 хуртэл¹ багц цагийн хичээлийг судална.

- 1.6. Магистр, докторын элсэлт авах хөтөлбөр, элсэлтийн бүртгэл, элсэлтийн шалгалтын хуваарь зэрэг элсэлттэй холбоотой бусад зүйлсийг элсэлт авах бүрт хавсралтаар баталж, уг мэдээллийг олон нийтийн Доржжавын
мэдээллийн хэрэгслүүд, <http://burtgel.num.edu.mn>, www.num.edu.mn, <http://graduate.num.edu.mn> цахим хуудсуудад байрлуулна.
- 1.7. Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудлыг МУИС-ийн Захирлын тушаалаар байгуулагдсан элсэлтийн төв комисс шийдвэрлэнэ.

2. Бүртгүүлэгчдэд тавих шаардлага

- 2.1. Магистрын хөтөлбөрт бакалаврын зэрэгтэй, докторын хөтөлбөрт магистрын зэрэгтэй бүртгүүлэгчийг элсүүлнэ.
- 2.2. Хууль Зүйн Сургуулийн магистрын хөтөлбөрт эрхзүйн бакалаврын, докторын хөтөлбөрт эрхзүйн магистрын зэрэгтэй иргэдийг элсүүлнэ.

3. Элсэлтийн бүртгэл

- 3.1. Намрын болон хаврын улиралд магистр, докторын хөтөлбөрийн элсэлтийн бүртгэлийг цахим хэлбэрээр явуулах бөгөөд элсэлт авах хөтөлбөр, хэлбэр (өдөр, эчнээ), хугацааг МУИС-ийн Захиргааны зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэж, улирал бүр <http://burtgel.num.edu.mn> вэб хуудсаар зарлана.
- 3.2. Элсэлтийн бүртгэл нь дараах алхмын дагуу явагдана. Үүнд:
 - 3.2.1. Бүртгүүлэгч нь МУИС-ийн бүртгэлийн системд хувийн мэдээлэл болон нэвтрэх мэдээллээ (цахим шуудангийн хаяг болон нэвтрэх үг) оруулж, элсэх хүсэлтээ гаргана.
 - 3.2.2. Бүртгүүлэхдээ бүртгэлийн систем дэх анкетыг бөглөж, дараах бичиг баримтуудыг цахим хэлбэрээр хавсаргана. Үүнд:
 - Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичгийн хуулбар (терсний гэрчилгээ, гадаад паспорт);
 - Эзэмшсэн боловсролын диплом, түүний хавсралтын хуулбар;
 - Цээж зураг (зурагт тавигдах шаардлагыг бүртгэлийн системээс үзнэ үү).
 - 3.2.4. Бүртгүүлэх боломжтой хөтөлбөрийн жагсаалтыг системээс харуулах бөгөөд бүртгүүлэгч элсэхийг хүссэн хөтөлбөрөө сонгоно.

¹ МУИС-ийн Захирлын тушаалаар баталсан 2015 оны 203 тоот “МУИС-ийн сургалтын журам”

- 3.2.5. Элсэхийг хүссэн хөтөлбөрийг сонгосон үед төлбөл зохих бүртгэлийн хураамжийн хэмжээ гарах бөгөөд хураамжийг цахим хэлбэрээр хийснээр бүртгэл баталгаажна.
- 3.4. Бүртгүүлэгч хэдэн ч хөтөлбөрт бүртгүүлж болох ба бүртгүүлсэн хөтөлбөрийн тоогоор хураамж төлнө.
- 3.5. Бүртгүүлэгч нь бүртгэлийн системд өөрийн гар утасны дугаар, цахим шуудангийн хаягийг заавал бүртгүүлэх бөгөөд энэ мэдээллийг үнэн зөв оруулсан байдлыг бүртгүүлэгч өөрөө хариуцна.
- 3.6. Бүртгүүлэгч хэдэн ч хөтөлбөрт шалгуулж болох ба элсэлтийн шалгалтандаа тэнцсэн өөрийн сонирхсон зөвхөн нэг хөтөлбөрт элсэх эрх авна.

4. Элсэлтийн шалгалт

- 4.1. Бүртгүүлэгч бакалаврын зэргийн боловсролоо МУИС-д эзэмшиж 3.0-аас дээш голчтой төгссөн бол тухайн мэргэжлээрээ МУИС-ийн магистрын хөтөлбөрт шалгалтгүйгээр элсэх боломжтой.
- 4.2. Бүртгүүлэгч нь элсэхийг хүссэн магистр, докторын хөтөлбөрийн мэргэжлийн чиглэлийн дагуу шалгалт өгнө. Шалгалтыг мэргэжлийн хөтөлбөрийн багш нараас бүрэлдэхүүн сургуулийн захирлын томилсон шалгалтын комисс тест болон бусад хэлбэрээр авах ба шалгалтын хэлбэрийг мэргэжлийн хөтөлбөр, тэнхимиин саналыг үндэслэн бүрэлдэхүүн сургууль шийдвэрлэх бөгөөд шалгалтыг бүртгүүлэгчийн тоон болон аналитик сэтгэлгээ, мэргэжлийн дагуух мэдлэгийг үнэлэх байдлаар онлайн хэлбэрээр явуулж болно. General GRE, Subject GRE зэрэг стандарт шалгалтуудын оноог элсэлтийн шалгалттай дүйцүүлэн тооцож болно.
- 4.3. Шалгалттай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг <http://burtgel.num.edu.mn> цахим хуудсанд элсэлт авах улирал бүрд байршуулна.
- 4.4. Магистр, докторын хөтөлбөрт нөхцөлтэй бүртгүүлэгч нь мэргэжлийн тэнхимиийн онцлогоос хамаарч шалгалт өгнө. Шалгалтыг хэрхэн зохион байгуулах, хөтөлбөрт ямар нөхцөлтэй элсүүлэн суралцуулахыг тухайн элсэгчийн мэргэжил, өмнө үзсэн хичээл зэргийг мэргэжлийн хөтөлбөр, тэнхимиийн саналыг үндэслэн Бүрэлдэхүүн сургуулийн захирал шийдвэрлэнэ.
- 4.5. Журмын 1.5-д заасны дагуу магистр, докторын хөтөлбөрт нөхцөлтэйгээр элссэн элсэгч нь элсэлтийн нөхцлөө биелүүлж, нөхөн судлах багц цагаа амжилттай гүйцээсэн бол үндсэн магистрын болон докторын хөтөлбөрт шалгалтгүй үргэлжлүүлэн суралцана.

- 4.6. Шалгалт дууссаны дараа бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын алба шалгалтын дүнг нэгтгэн гаргаж бүртгэлийн системд оруулна.
- 4.7. Шалгалт авах өдөр, цаг, байр болон шалгалтын талаарх мэдээллийг бүртгэлийн хугацаанд <http://burtgel.num.edu.mn> цахим хуудсанд байршуулна.
- 4.8. Шалгалтад авбал зохих нийт онооны 60-аас доошгүй хувийг авсан тохиолдолд МУИС-д элсэх болзол хангасан гэж үзнэ.

УХДС072 9104399

5. Элсэгчийг шалгаруулах ба мэдэгдэх

- 5.1. Бүртгүүлэгчдэд шалгалтын дүнг МУИС-ийн бүртгэлийн системээр мэдэгдэнэ. Эрэлт ихтэй зарим хөтөлбөрийн хяналтын тоог бүрэлдэхүүн сургуулиуд шийдвэрлэх бөгөөд үүнийг журмын хавсралтаар баталж, бүртгэлийн системээр мэдээлнэ.
- 5.2. Бүртгүүлэгчдийг шалгалтын нийт онооны дарааллаар жагсаах ба элсэх болзол хангасан бүртгүүлэгчдийн бүртгэлийн дугаарыг Бүрэлдэхүүн сургуулийн мэдээллийн самбар болон цахим хуудсаар албан ёсоор зарлана.
- 5.3. Шалгалтад тэнцсэн элсэгч бүртгүүлэхээр ирэхдээ дараах материалыг бүрдүүлж, битүүмжлэл сайтай хавтсанд хийсэн байна. Үүнд:
- Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг (төрсний гэрчилгээ, гадаад паспорт), хуулбарын хамт;
 - Өмнө нь эзэмшсэн боловсролын диплом, хавсралт (бакалавр болон магистрын диплом/ хуулбарын хамт);
 - Цээж зураг хоёр хувь, бүртгэлийн системийн шаардлагад нийцсэн цээж зураг файл хэлбэрээр (сүүлийн гурван сард авахуулсан).
- 5.4. Бүртгэлийн мэдээллийг бичиг баримтын эх хувьтай тулгаж, бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанад баталгаажуулна.

6. Гадаадын иргэнийг бүртгэх, элсүүлэх

- 6.1. Гадаадын иргэнийг магистр, докторын зэрэг олгох хөтөлбөр, оюутан солилцооны хөтөлбөр болон Монгол хэлний бэлтгэл хөтөлбөрт элсүүлэх элсэлтийг хичээлийн жилд хоёр удаа зохион байгуулна.²
- 6.2. Магистр, докторын хөтөлбөрт элсэх гадаадын иргэн Монгол улсад мөрдөгдөж буй боловсролын агуулгын түвшин, стандарттай дүйцэхүйц өмнөх шатны боловсрол эзэмшсэн байна.

² МУИС-ийн Захирлын 2014 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн А/214 тоот тушаалын хавсралт

- 6.3. Бүртгүүлэх боломжтой хөтөлбөрийн жагсаалтыг бүртгүүлэгч МУИС-ийн вэб хуудас болон гадаад элсэгчдэд зориулсан "Graduate Prospectus"-аас танилцаж, элсэхийг хүссэн хөтөлбөрөө сонгоно.
- 6.4. МУИС-д элсэн суралцах хүсэлтэй гадаадын иргэн Сургалтын нэгдсэн албандаа цахим шуудангаар хүсэлт гаргана (studentaffairs@num.edu.mn). Элсэн суралцах хүсэлтийг хичээл эхлэхээс 45-аас доошгүй хоногийн өмнө гаргасан байна.
- 6.5. Гадаадын иргэн нь элсэн суралцах тухай өргөдлийн маягт (Хавсралт үз)-ыг бөглөж дараах бичиг баримтуудын хуулбарыг хавсаргана. Үүнд:
- Эзэмшсэн боловсролын диплом, гэрчилгээ, дүнгийн хавсралтын хуулбар (монгол эсвэл англи хэлээр орчуулж, баталгаажуулсан);
 - Гадаадын иргэн болохыг нотлох албан ёсны бичиг баримт (паспортын хуулбар);
 - Монгол хэлээр, эсвэл англи хэлээр бичсэн эссе (магистрантурт бүртгүүлэгч 1500-1800 үтэй, докторантурт бүртгүүлэгч 2300-2500 үтэй эссе бичиж ирүүлнэ);
 - Бүртгүүлэгчийн Монгол улсад суралцах хугацааны сургалтын төлбөр, амьдрах зардлыг хариуцах байгууллага, хувь хүнээс гаргасан санхүүгийн баталгаа;
 - Бүртгүүлэгчийн мэдлэг боловсрол, ажлын туршлага, суралцах арга барилыг тодорхойлсон профессор багш болон удирдах ажилтны тодорхойлолт (Хавсралт үз);
 - Бүртгүүлэгчийн төрөлх хэл нь монгол хэл биш бол монгол, англи хэлний мэдлэг, чадварын түвшнийг илтгэх баримт (сүүлийн хоёр жилийн хугацаанд хүчинтэй TOEFL, IELTS, General GRE, Subject GRE зэрэг стандарт шалгалтын оноо);
 - Эрүүл мэндийн маягт (<http://burtgel.num.edu.mn> цахим хуудсанд байршуулсан загварын дагуу дээрх бүртгэлийн хугацаанд эмнэлгээс олгосон байх, Хавсралт үз);
 - Цээж зураг (сүүлийн турван сард авахуулсан, 3x4 см-ийн хэмжээтэй байх);
 - Гадаад бүртгүүлэгчийн хувьд тухайн хичээлийн жилд тогтоогдсон үйлчилгээний хураамжийг ам.доллараар төлсөн баримт.
- 6.6. Хоёр улсын Засгийн газар хоорондын болон хоёр тал (МУИС ба гадаадын байгууллага, иргэн)-ын гэрээ, хэлэлцээрийн дагуу суралцах, мэргэжил

дээшлүүлэх, судлаачаар ажиллах гадаадын иргэдийг БСШУ-ны Сайд, МУИС-ийн Захирлын тушаалаар шууд элсүүлэн суралцуулна.

- 6.7. Сургалтын нэгдсэн алба холбогдох мэргэжлийн тэнхим/салбартай хамтран тухайн сургуульд суралцах хүсэлт гаргасан гадаадын иргэний өргөдлийг хүлээн авч, өргөдлийг хүсэлт хүлээн авсан сүүлийн өдрөөс хойш хоёр долоо хоногийн дотор хянаж, суралцуулах тухай шийдвэр гаргана.
- 6.8. Гадаад иргэний МУИС-д элсэн суралцах хүсэлт шийдвэрлэгдсэнээс хойших Монгол Улсад ирэх, оршин суухтай холбоотой асуудлууд болон нийгэм, соёл, хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг Сургалтын нэгдсэн алба, Оюутанд үйлчлэх төв, бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын алба хариуцна.

7. Бусад

- 7.1. Бүртгүүлэгчийг нэг бүрэлдэхүүн сургуулиас нөгөө бүрэлдэхүүн сургуульд шилжүүлэн элсүүлэхгүй.
- 7.2. Бүртгүүлэгч системд бүртгүүлсэн боловч МУИС-ийн үйл ажиллагаанаас үл хамаарсан шалтгаанаар элсэлтийн шалгалтыг өгөөгүй бол бүртгэлийн хураамжийг буцааж олгохгүй.
- 7.3. Элсэх болзол хангасан боловч заасан хугацаанд ирж баталгаажуулаагүй (суралцах гэрээ байгуулаагүй) бүртгүүлэгчийг суралцахаас татгалзсан гэж үзэн элсэх эрхийг хүчингүйд тооцно.
- 7.4. Элсэлттэй холбоотой бичиг баримтыг хурамчаар үйлдвэл МУИС-д элсүүлэхгүй бөгөөд хуурамч бичиг баримтаар элссэн нь тогтоогдсон тохиолдолд сургуулиас хасч, хуулийн байгууллагад мэдэгдэнэ.
- 7.5. Элсэлтийг цахим хэлбэрээр явуулахад зориулсан цахим хуудас нь бүтэн жилийн турш тогтмол ажиллагаатай байж, элсэлтийн талаарх мэдээллээр бүртгүүлэгчдийг хангана.
- 7.6. Цахим бүртгэл явагдаж байх үед МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиуд хөтөлбөрүүдээ танилцуулах, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг утас, цахим шуудангаар зохион байгуулна.

Захирлын 2015 оны 07 дугаар сарын 10 -ны
өдрийн 11 дугаар тушаалын 2 дугаар хавсралт
12.20

ХД0072 9104399

2015-2016 оны хичээлийн жилийн намрын улирлын

магистр, докторын хөтөлбөрийн бүртгэл, элсэлт

Элсэлтийн бүртгэл:

2015 оны 7 дугаар сарын 15-наас 8 дугаар сарын 27-ны өдрийн 18:00 цаг хүртэл

Бүртгэлийн хураамж:

Монгол Улсын иргэн 25,000 төгрөг, гадаадын иргэн 50 ам. Доллар

Сургалт эхлэх хугацаа: 2015 оны 9 дүгээр сарын 7-ноос эхэлнэ.

2015-2016 оны хичээлийн жилийн намрын улиралд элсүүлэх
магистрын хөтөлбөрүүд

№	Бүрэлдэхүүн сургууль	Сонгох боломжтой хөтөлбөр	Элсэлтийн шалгалт	
			Суурь шалгалт	Дагалдах шалгалт
			I	II
1	Шинжлэх Ухааны Сургууль- Нийгмийн Ухааны Салбар	Антрапологи, Археологи,	Мэргэжил (ярилцлага)	Мэргэжил (бичгээр)
		Улс төр судлал,	Мэргэжил	Гадаад хэлний чадвар
		Сэтгүүлзүй, Эдийн засаг	Мэргэжил (бичгээр)	Мэргэжил (амаар)
		Социологи, Нийгмийн ажил, Сэтгэл судлал, Боловсрол судлал		Мэргэжил
2	Шинжлэх Ухааны Сургууль- Хүмүүнлэгийн Ухааны Салбар	Түүх, Философи, Буддын гүн ухаан, Шашин судлал	Мэргэжил	Гадаад хэлний чадвар
		Утга зохиол судлал, Урлаг судлал	Мэргэжил	Ярилцлага
		Хэл шинжлэл, Монгол хэл, уран зохиолын боловсрол		Мэргэжил

		Гадаад хэл шинжлэл, Гадаад хэлний боловсрол, Олон улс, орон судлал, Гадаад хэлний орчуулга	Мэргэжил	Гадаад хэлний чадвар
3	Шинжлэх Ухааны Сургууль	Хими, Химийн боловсрол, Биохими, Биотехнологи, Биологи, Биологийн боловсрол, Экологи, Биофизик, Байгалийн нөөц судлалын менежмент*, Математик, Математикийн боловсрол, Геологи (эрэл хайгуул, шатах ашигт малтмал, эрдэс баялгийн удирдлага), Геофизик	Мэргэжил 10072 9104399	Мэргэжил
	Байгалийн Ухааны Салбар	Хот ба бус нутаг төлөвлөлт, Газрын кадастр, Газар зохион байгуулалт, Байгаль орчны зайнлас тандан судлал, Газарзүйн мэдээллийн систем, Газарзүй, Газарзүйн боловсрол, Хөрс судлал	Мэргэжил (бичгээр)	Мэргэжил (амаар)
		Физик, Физикийн боловсрол	Мэргэжил	Гадаад хэлний чадвар
4	Хэрэглээний Шинжлэх Ухаан, Инженерчлэлийн Сургууль	Хэрэглээний математик, Статистик, Цаг уур-Ус судлал, Сэргээгдэх эрчим хүч, Цөмийн технологи, Хүрээлэн буй орчин судлал, Цөмийн эрчим хүч, Байгаль хамгаалал, технологи, Хэрэглээний хими, Химийн инженерчлэл, Материал судлал, шинэ материалын технологи, Нано шинжлэх ухаан, инженерчлэл, Ойн аж ахуй, ойн зохион байгуулалт, Програм хангамж, Мэдээллийн систем, Мэдээллийн технологи, Биоинформатик, Өгөгдлийн сангийн загварчлал, удирдлага, Компьютер хэл шинжлэл, Компьютер ухаан	Мэргэжил	Шалгалтын хэлбэрийг тухайн мэргэжлийн тэнхим шийднэ
5	Бизнесийн Сургууль	Нягтлан бодох бүртгэл, Санхүү банк даатгал, Менежмент, Аялал жуулчлалын менежмент, Маркетинг, Худалдаа, Зочлох үйлчилгээ, Бизнесийн удирдлага	Нэгдсэн сорилго	
6	Хууль Зүйн Сургууль	Эрхзүй, Олон улсын эрхзүй	Мэргэжил	

7	Олон Улсын Харилцаа, Нийтийн Удирдлагын Сургууль	Олон улсын харилцаа, Бүс нутаг судлал, Нийтийн удирдлага	Эссе** ХД0072 9104399	Ярилцлага
8	Орхон сургууль	Нягтлан бодох бүртгэл, Санхүү, банк, даатгал, Менежмент, Гадаад хэлний боловсрол, Боловсрол судлал	Нэгдсэн сорилго (мэргэжил, англи хэл)	

* БСШУЯ-ны шийдвэрээс элсэлт авах эсэх хамаарна.

** Эссе нь бүртгүүлэгч тухайн мэргэжлээр ахисан түвшинд суралцахаар сонгосон шалтгаан, ойрын болон алсын зорилго, уг мэргэжлийн чиглэлд элсэн суралцсанаар зорилгоо биелүүлэхэд дөхөм болох давуу тал, тухайн мэргэжлийн салбарын хөгжил, мэргэжлийн хамт олонд оруулна гэж төсөөлж буй хувь нэмэр, сонгосон чиглэлээр хуристлуулсан дадлага туршлага, мэргэжлийн бэлтгэл зэргийн өгүүлсэн 1500-1800 үтгэй бичвэр байна.

**2015-2016 оны хичээлийн жилийн намрын улиралд элсүүлэх
докторын хөтөлбөрүүд**

№	Бүрэлдэхүүн сургууль	Сонгох боломжтой хөтөлбөр	Элсэлтийн шалгалт	
			Суурь шалгалт	Дагалдах шалгалт
			I	II
1	Шинжлэх Ухааны Сургууль- Нийгмийн Ухааны Салбар	Антрапологи, Археологи	Мэргэжил (ярилцлага)	Мэргэжил (бичгээр)
		Улс төр судлал	Мэргэжил	Гадаад хэлний чадвар
		Сэтгүүлзүй, Эдийн засаг	Мэргэжил (бичгээр)	Мэргэжил (амаар)
		Социологи, Нийгмийн ажил, Сэтгэл судлал, Боловсрол судлал	Мэргэжил	
2	Шинжлэх Ухааны Сургууль- Хүмүүнлэгийн Ухааны	Философи, Буддын гүн ухаан, Шашин судлал	Мэргэжил	Гадаад хэлний чадвар
		Утга зохиол судлал, Урлаг судлал	Мэргэжил	Ярилцлага
		Хэл шинжлэл, Олон улс, орон судлал,	Мэргэжил	

	Салбар	Түүх		
		Гадаад хэл шинжлэл, Гадаад хэлний орчуулга	Гадаад хэл шинжлэл Гадаад хэлний орчуулга Мэргэжил ХД0072 9104399	Гадаад хэлний чадвар
4	Шинжлэх Ухааны Сургууль-Байгалийн Ухааны Салбар	Хими, Биохими, Биологи, Экологи, Биофизик, Математик, Геологи, Геофизик	Мэргэжил	Мэргэжил
		Газарзүй	Мэргэжил (бичгээр)	Мэргэжил (амаар)
		Физик	Мэргэжил	Гадаад хэлний чадвар
5	Хэрэглээний Шинжлэх Ухаан, Инженерчлэлийн Сургууль	Хэрэглээний математик, Цөмийн технологи, Хүрээлэн буй орчин судлал, Хэрэглээний хими, Ой аж ахуй, ойн зохион байгуулалт	Мэргэжил	Шалгалтын хэлбэрийг мэргэжлийн тэнхим шийднэ
6	Бизнесийн Сургууль	Бизнесийн удирдлага	Судалгааны чиглэлийн дагуу эссе	Ярилцлага
7	Хууль Зүйн Сургууль	Эрхзүй	Эссе*	Ярилцлага
8	Олон Улсын Харилцаа, Нийтийн Удирдлагын Сургууль	Олон улсын харилцаа	Эссе*	Ярилцлага

* Эссе нь бүртгүүлэгч тухайн мэргэжлээр ахисан түвшинд суралцахаар сонгосон шалтгаан, ойрын болон алсын зорилго, уг мэргэжлийн чиглэлд элсэн суралцсанаар зорилгоо биелүүлэхэд дэхөм болох давуу тал, тухайн мэргэжлийн салбарын хөгжил, мэргэжлийн хамт олонд оруулна гэж төсөөлж буй хувь нэмэр, сонгосон чиглэлээр хуримтлуулсан дадлага туршлага, мэргэжлийн бэлтгэл зэргийн өгүүлсэн 2300-2500 ўгтэй бичвэр байна.



**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬД
гадаадын иргэний элсэн суралцах тухай өргөдөл**

**National University of Mongolia
Application Form for Admission of International Applicants**

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ НЬ:

TO APPLICANT:

Please complete this form in Mongolian or English and print in BLOCK LETTERS.

Логотип
AAB0072 91048
Нээж зургийг
энд
байрлуулна
уу.
Attach a recent
passport-sized
photograph
here

I. Хувийн мэдээлэл Personal Information

Овог <i>Family Name</i>			
Өөрийн нэр <i>Given name</i>			
Төрсөн он сар өдөр <i>Date of Birth</i> (Year/Month/Day)	Xүйс <i>Gender</i>	<input type="checkbox"/> Эр <i>Male</i>	<input type="checkbox"/> Эм <i>Female</i>
Иргэншил <i>Nationality</i>	Tөрсөн газар <i>Place of Birth</i>		Паспортын дугаар <i>Passport No.</i>
Төрөлх хэл <i>Native language</i>			
Гэрийн хаяг <i>Home Address</i>			
Шуудангийн хаяг <i>Mailing Address</i>			
Цахим хаяг <i>E-mail</i>			
Утас <i>Telephone</i>		Факс <i>Fax</i>	
Гэрлэсэн эсэх <i>Marital status</i>	<input type="checkbox"/> Гэрлэсэн <input type="checkbox"/> Гэрлээгүй <i>Married</i>	Single	Хүүхдийн тоо <i>No. of Children</i>
Монгол дахь холбоо барих хүн <i>Contact Person in Mongolia</i>	Нэр <i>Name</i>		
	Утас <i>Telephone</i>		Цахим хаяг <i>E-mail</i>
	Хаяг <i>Address</i>		

II. Боловсрол
Educational Background

Сургууль: <i>Institution:</i>		 ГХД 0072 9104399
Он сар: <i>Date (From-To):</i>		
Эзэмшсэн зэрэг, цол: <i>Degree or Diploma Obtained:</i>		
Сургууль: <i>Institution:</i>		
Он сар: <i>Date (From-To):</i>		
Эзэмшсэн зэрэг, цол: <i>Degree or Diploma Obtained:</i>		
Сургууль: <i>Institution:</i>		
Он сар: <i>Date (From-To):</i>		
Эзэмшсэн зэрэг, цол: <i>Degree or Diploma Obtained:</i>		

Please provide a copy of the diploma/certificate of education (translated into English or Mongolian)

III. Суралцах хөтөлбөр (Preferred program)
For which degree do you wish to apply?

МУИС-ийн бүрэлдэхүүн сургууль <i>School of NUM</i>		
Хөтөлбөр <i>Program</i>	Хөтөлбөрийн нэр: <i>Name of the program:</i>	<input type="checkbox"/> Монгол хэлний бэлтгэл <i>Mongolian language Learning</i>
	<input type="checkbox"/> Оюутан солилцоо <i>Student Exchange</i>	<input type="checkbox"/> Мэргэжил дээшлүүлэх, судлаачаар ажиллах <i>Researcher</i>
	<input type="checkbox"/> Магистр <i>Master</i>	<input type="checkbox"/> Доктор <i>Doctor</i>

IV. Санхүүгийн мэдээлэл
Financial Support: What will be your major source of financial support during study?

<input type="checkbox"/> Хувиараа <i>Personal Savings</i>
<input type="checkbox"/> Эцэг эхийн дэмжлэг <i>Parental Support</i>
<input type="checkbox"/> Засгийн газрын тэтгэлэг <i>Governmental Scholarship</i>
<input type="checkbox"/> Тэтгэлэг <i>Scholarship</i> Төрөл <i>Source</i> _____ Нийт дүн <i>Amount</i>
<input type="checkbox"/> Бусад <i>Other Resources</i>

V. Дотуур байр

Dormitory


Дотуур байранд амьдрах уу? Would you like to apply for a dormitory room?

Тийм, Дотуур байранд амьдрах хүсэлтэй байна.

Yes, I would like to live in dormitory and comply with all regulations.

Үгүй, Дотуур байранд амьдрахгүй.

No, please do not reserve dormitory for me.



VI. Хэлний түвшин

Languages Proficiency

©Англи хэл English Language Proficiency

Англи хэлний төвшин тогтоох шалгалт өгсөн үү? Have you taken any English proficiency test?	<input type="checkbox"/> Тийм Yes <input type="checkbox"/> Үгүй No	Хэрвээ өгсөн бол шалгалтын нэр If yes, what is the name of the test?	
		Оноо Score	

Англи хэлний өөрийн түвшингөө тодорхойлно уу. Please evaluate your English language skills.

Сонсох Listening	<input type="checkbox"/> Mash сайн Excellent	<input type="checkbox"/> Сайн Good	<input type="checkbox"/> Дунд Fair	<input type="checkbox"/> Muy Poor
Ярих Speaking	<input type="checkbox"/> Mash сайн Excellent	<input type="checkbox"/> Сайн Good	<input type="checkbox"/> Дунд Fair	<input type="checkbox"/> Muy Poor
Унших Reading	<input type="checkbox"/> Mash сайн Excellent	<input type="checkbox"/> Сайн Good	<input type="checkbox"/> Дунд Fair	<input type="checkbox"/> Muy Poor
Бичих Writing	<input type="checkbox"/> Mash сайн Excellent	<input type="checkbox"/> Сайн Good	<input type="checkbox"/> Дунд Fair	<input type="checkbox"/> Muy Poor

© Монгол хэл Mongolian Language Proficiency

Монгол хэлийг хэдэн жил сурсан бэ? How many years have you formally studied Mongolian?				
Монгол хэлийг хаана, ямар сургуульд сурсан бэ? Where did you study Mongolian (high school, college, language institute)?				
Монгол хэлний төвшингөө тодорхойлно уу. Please evaluate your Mongolian language skills.				
Сонсох Listening	<input type="checkbox"/> Mash сайн Excellent	<input type="checkbox"/> Сайн Good	<input type="checkbox"/> Дунд Fair	<input type="checkbox"/> Muy Poor
Ярих Speaking	<input type="checkbox"/> Mash сайн Excellent	<input type="checkbox"/> Сайн Good	<input type="checkbox"/> Дунд Fair	<input type="checkbox"/> Muy Poor
Унших Reading	<input type="checkbox"/> Mash сайн Excellent	<input type="checkbox"/> Сайн Good	<input type="checkbox"/> Дунд Fair	<input type="checkbox"/> Muy Poor
Бичих Writing	<input type="checkbox"/> Mash сайн Excellent	<input type="checkbox"/> Сайн Good	<input type="checkbox"/> Дунд Fair	<input type="checkbox"/> Muy Poor

※ Хэлний төвшинг илэрхийлсэн баримтыг хавсаргана уу.

Please submit the copies of all the related certificates along with this form.

VII. Бусад Others

- Хөгжлийн бэрхшээлтэй бол бичнэ үү. Please specify physical illness or disability if applicable.
- Хэрэв хэвлэгдсэн бүтээлтэй бол жагсаалтыг (Бүтээлийн нэр, хэвлэгдсэн жил,

хэвлэлийн газар) бичнэ үү.

- Please list your publications, including the published year, titles of publications, publishers, published locations, if applicable.
- Хувийн амжилт болон ажлын туршлага. Honored Activities and Working Experiences.

Cap/ жил Month/Year	Бүрэн/ Бүрэн бус Full/Part Time	Байгууллагын нэр Name of Organization	Албан тушаал Position Held

VIII. Where (in which Mongolian Embassy) would you intend to apply for visa?

IX. Checklist

I have included in this application form:

- A photo copy of passport (valid at least for a year from preferred period)
- A copy of certificate/diploma of education with academic transcript (translated into English or Mongolian)
- Two passport-size photos
- Complete medical form including HIV test
- Payment for registration fee (\$50 for international applicants: personal check and international money order made payable to the National University of Mongolia or wire transfer to account #: 110 292 7753, account name: MUIS, bank: Golomt Bank of Mongolia; SWIFT code: GLMTMNUB)

X. Declaration

I declare that the information provided in this application is correct and true.

Өргөдөл гаргагчийн гарын үсэг *Applicant's Signature:*

Өргөдөл гаргасан он сар өдөр *Date of application (Y/M/D):* _____

Should you have any further questions on application form, please do not hesitate to contact us by email: studentaffairs@num.edu.mn



Scholarship Awards – Scholarships



Referee report

The applicant has named you as a referee in support of an application for graduate program at the National University of Mongolia. To assist in the selection process, we would like to receive your views on the applicant's suitability for graduate studies, in particular on their capabilities and personal qualities, academic competence (including, where applicable, their research ability) and potential outcomes.

1. Personal details

Applicant's details

Full name (as it appears in passport)			
Email			
Area of research interest			

Referee's details

Family name					
Given names					
Mobile no.			Work		
Email					
Employing organization	Name				
	Town/City,				
Position title				Starting date / /	
Length of time you have known applicant	<input type="checkbox"/> Less than 3 months	<input type="checkbox"/> 3–12 months	<input type="checkbox"/> 1–2 years	<input type="checkbox"/> 2–5 years	<input type="checkbox"/> More than 5 years
Relationship to applicant (e.g. direct supervisor, lecturer, peer, etc)					
Authorised official stamp of the organisation.					

2. Evaluation of applicant's capabilities and behaviours

Please evaluate the applicant against the following criteria

	Very	Satisfact	Needs	Not
Shapes strategic thinking (meaning that they: inspire a sense of purpose and direction; focus strategically; harness information and opportunities; and show judgement, intelligence and commonsense)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/> 100729104399	<input type="checkbox"/>
Achieves results (meaning that they: build organisation capability and responsiveness; marshal professional expertise; steer and implement change and deal with uncertainty; ensure closure and deliver on intended results)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Cultivates productive working relationships (meaning that they: nurture internal and external relationships; facilitate cooperation and partnerships; value individual differences and diversity; and guide, mentor and develop people)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Displays personal drive and integrity (meaning that they: demonstrate professionalism and probity; commit to action; display resilience; promote and adopt a positive and balanced approach to work; and demonstrate self awareness and a commitment to personal development)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Communicates and negotiates effectively (meaning that they: communicate clearly; listen, understand and adapts to audience; and negotiates persuasively)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

3. General comments

Why should the applicant be considered for a Scholarship?

4. Academic referee comments – applicable to PhD candidates only

In the past five years, how many research higher degree (PhD, Master's) candidates have you worked with?

Your professional knowledge of the applicant is: Very detailed Very good
 Good Incomplete

30072 9104399

Score the following criteria out of 10 (A score of 10 means that you regard the applicant as being in the top 2% of all candidates in each assessment category. A score of 9 indicates that the applicant is in the top 5% of all candidates. A score of 8 - top 10%; score of 7 - top 20%; score of 6 - top 30%; score of 5 - top 40%; score of 4 - upper 50%; score of 3 - upper 60%; score of 2 - upper 70%; score of 1 - bottom 30%)

Score

(a) **Research potential:** intrinsic research potential (as distinct from examination results).

(b) **Creative Ability:** ability to develop original ideas/hypotheses, to write original compositions or to assemble conventional work in some original way

(c) **Initiative:** ability to embark on new ideas or approaches without prompting

(d) **Perseverance:** ability to work steadily even in difficult circumstances or where motivation or external direction is minimal.

(e) **Critical thinking:** ability to differentiate between sound and irrationality based thinking

(f) **Team work:** ability to work in a research group

(g) **Ability to Communicate:** both written and spoken

Please comment on evidence of the applicant's research potential and achievement (such as the outcomes of their research experience and training, including university studies, publications, papers, and other relevant work) and any other comments relevant to the applicant's admission to a PhD (maximum 300 words).

5. Referee's declaration and signature

I declare that the information in this report is true and correct.

Signature

Date / /


Thank you for assisting the National University of Mongolia in identifying an outstanding candidate for its graduate programs. Please return this form to: Academic Office, National University of Mongolia, Ikh Surguuliin Gudamj 1, Ulaanbaatar 14200, Mongolia. Email: studentaffairs@num.edu.mn



NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA

CERTIFICATE OF HEALTH

(to be completed by the examining physician)



Family Name: _____ Given Name (s): _____

Sex (Male/Female): _____ Date of Birth (Day/Month/Year) _____

Place of Birth: _____ Country of Citizenship: _____

1. Physical Examinations

(1) Height _____ cm Weight _____ kg

(2) Blood pressure _____. ____ mm/Hg _____ mm/Hg Blood Type: ABO /RH + -

Pulse: regular / irregular

(3) Eyesight: (R) _____ (L) _____ (R) _____ (L) _____ color blindness: normal
without glasses with glasses or contact lenses impaired

(4) Hearing: normal Speech: normal
impaired impaired

2. Please describe the results of physical and X-ray examinations of applicant's chest x ray (X-ray taken more than 6 months prior to the certification is NOT valid)

Lung: normal Cardiomegaly: normal
impaired impaired

Date _____ Electrocardiograph: normal

Film No _____ impaired

Describe the condition of applicant's lung _____

3. Disease: Treated at Present: Yes (Disease: _____) No

4. **Past history:** Please indicate with + or - and fill in the date of recovery

Tuberculosis		Malaria		Other communicable	
Epilepsy		Kidney Disease		Heart Diseases	
Diabetes		Drug Allergy		Psychosis	

17/07/2010 10:42:59

5. **Laboratory tests**

Urinalysis: glucose () Protein () Occult blood ()

ESR: _____ mm/Hr. WBC count: _____ cmm anemia _____

Hemoglobin: _____ gm GPT: _____

6. Is the person examined medically free from the acquired immune deficiency syndrome (AIDS)?

7. Is the person examined physically and mentally able to carry on intensive study away from his home?

8. Does the person examined have any condition or defect which might require treatment during his fellowship?

9. In view of the applicant's history and the above findings, is it your observation his/her health status is adequate to pursue studies in Mongolia.

Yes _____ No _____

Date: _____ Signature: _____

Physician's Name in Print: _____

Department Office: _____

Address: _____

Phone No: _____